

**ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Дундговь-Ус ОНӨҮГазар
2. Төслийн байршил: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг
3. Огноо: 2023.02.27

4. Үнэлгээний хүснэгт

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн дундаж оноо	Үндэслэл, тайлбар
	1	2	3	4
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	17	2 зуухны янданд утаа шүүгч байруулсан. Төлөвлөгөө 80 хувьтай хэрэгжсэн.
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	29	Улсын чанартай зам дагуу мод тарьсан. Байгууллагын гадна модны төрөл тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	Түүх соёлын өвтэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй.
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	15	Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлсэн.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	Ангилан ялгах хогийн сав байршуулж бүртгэл хөтлөн, сумтай гэрээ байгуулсан.
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	10	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.
9	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4.1	Төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах.
10	Аймаг, сум орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	0	Оршин суугчдад тайлагнах ажил хийгдээгүй.
Нийт оноо		100	90.1	

5. Дүгнэлт:

Тус газрын 2023 оны 03 тоот хүсэлтийг үндэслэн 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ажлын хэсгийн гишүүд тус бүр үнэлгээг өгч, оноог дундажлан дээрх хүснэгтэд үзүүлсний дагуу 90.1 хувьтай дүгнэгдлээ.

Төлөвлөсөн ажлын хүрээнд ажлыг хийж гүйцэтгэсэн боловч тайлангийн боловсруулалт дунд түвшинд байв.

6. Санал, зөвлөмж

6.1 2023 оны БОМТөлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, батлуулахад анхаарах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу хийгдэх ажлыг сайтар төлөвлөж, хэрэгжүүлэх.

6.2 Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүрийн эхний улиралд багтаан гаргуулж, гэрээ байгуулах.

6.3 2023 оны тайланг заасан хугацаанд буюу 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх.

6.4 Сайнцагаан сумын төвийн багийн иргэдэд үйл ажиллагааг танилцуулах ажлыг багийн ИНХурал болон орон нутгийн албан ёсны цахим хаягт байршуулан иргэдийг мэдээллээр сайтар хангах, фото зургаар баримтжуулан тайланд хавсаргах.

6.5 Төлөвлөсөн ажлын хүрээнд хийгдсэн ажлын тайланг зурагжуулах, тоо баримтыг тэмдэглэж байх.

6.6 БОМТөлөвлөгөөний зардлыг бүрэн гаргаж үр дүнг дээшлүүлэхэд анхаарах.

6.7 2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайлангийн чанар, эмх цэгцэд анхаарч, баримт бичгийн стандартад нийцүүлж, тайлангийн хавсралтыг журмын дагуу бүрэн бүрдүүлсэн үед ажлын хэсэг хүлээн авахыг тус тус зөвлөж байна.

7. 2023 оны төлөвлөгөөнд зайлшгүй тусгах арга хэмжээ

7.1 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан бохирдлын үзүүлэлтийг тодорхойлуулан гарсан бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөх.

7.2 “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговно ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар сум орон нутгийн байгууллагатай зөвшилцөн төлөвлөж, үр дүн гарган ажиллах.

7.3 Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор байгальд ээлтэй тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах.

7.4 Хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах.

7.5 Хог хаягдлыг ангилан ялгах менежментийг хэрэгжүүлэх



АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:  Н.ГАНТУЛГА (БОАЖГ-ын дарга)

НЭГТГЭН ДҮГНЭСЭН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА :



Б.НЯМТУЯА (БОАЖГ-ын мэргэжилтэн)

ГИШҮҮД:



З.НАРАНМАНДАХ (БОХУБайцаагч)

Б.ЦЭРЭНСУГИР (БОАЖГ-ын мэргэжилтэн)

Ж.МИЕЭСҮРЭН (Сайнцагаан сумын БОХУБ)



ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:



О.БАРХҮҮ

(ДУНДГОВЬ-УС ОНӨУГАЗРЫН ЗАХИРАЛ)

**ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ДҮГНЭХ ХУУДАС**

АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР: ДУНДГОВЬ-УС ОНӨУГАЗАР

ТӨСЛИЙН НЭР: УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУURГА, ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛ

ТӨСЛИЙН БАЙРШИЛ: ДУНДГОВЬ АЙМАГ, САЙНЦАГААН СУМ, 7-Р БАГ

ОГНОО: 2023.02.27

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо					Гишүүдийн дундаж оноо	Үндэслэл, тайлбар	
			Ажлын хэсгийн дарга	Гишүүн	Гишүүн	Гишүүн	Гишүүн			
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	20	3	4	5	17	17	17.1	8	2 зуухны янданд утаа шүүгч байруулсан. Төлөвлөгөө 80 хувьтай хэрэгжсэн.
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	29	29	29	29	29	29	29	Улсын чанартай зам дагуу мод тарьсан. Байгууллагын гадна модны төрөл тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
3	Түүх, соёлын өвийг хамгаалах	5	5	5	5	5	5	5	5	Түүх соёлын өвтэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй.
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	15	15	15	15	15	15	15	Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлсэн.

5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10	Ангилан ялгах хогийн сав байршуулж бүртгэл хөтлөн, сумтай гэрээ байгуулсан.
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	10	10	10	10	10	10	10	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4	4.1	4.3	3.9	4.2	4.1	4.1	Төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах.
8	Нөлөөллийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	0	0	0	0	0	0	0	Оршин тайлагнах хийгдээгүй.
9	Нийт оноо	100	89.9	90.1	90.3	89.9	90.3	90.1	90.1	

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

Н.ГАНТУЛГА (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЦГИЙН ДАРГА:

Б.НЯМТУЯА (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)


ГИШҮҮД:

3. НАРАНМАНДАХ (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Б.ЦЭРЭНСУГИР (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Х.А.Ж.МИЕЭСҮРЭН (Сайнцагаан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН: О.БАРХҮҮ (ДУНДГОВЬ-УС ОНӨУГАЗРЫН ЗАХИРАЛ)



АГУУЛГА

БҮЛЭГ 1. Төслийн товч танилцуулга	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төслийн зорилго	3
1.3. Төслийн хэрэгжүүлэгчийн нэр, хаяг	3
1.4. Төслийн үйл ажиллагааны чиглэл	3
1.5. Төслийн байршил	3
1.6. Төслийн төлөвлөлт, хүчин чадал.....	4
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ	14
2.1. Физик газарзүйн нөхцөл.....	14
2.2. Уур амьсгалын нөхцөл	17
2.3. Гадаргын ус	20
2.4. Газрын доорх ус	20
2.5. Хөрсөн бүрхэвч	21
2.6. Ургамлан нөмрөг	22
2.7. Амьтны аймаг	22
2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг.....	23
2.9. Нийгэм эдийн засгийн байдал	23
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	24
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ.....	25
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	32
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
БҮЛЭГ 12. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ус хангамжийн эх үүсвэрийн мэдээлэл.....	8
Хүснэгт 2. Мандалговь хотын хур тунадасны үзүүлэлт	18
Хүснэгт 3. Мандалговь хотын салхины үзүүлэлт	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил	4
Зураг 2. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын төв байрны байршлын тойм зураг	5
Зураг 3. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын төв байрны орчны тойм зураг	5
Зураг 4. Олгойн говьд байрлах ус хангамжийн эх үүсвэрүүд, тэдгээрийн байршил	6
Зураг 5. 1-р эх үүсвэр (Олгойн говь).....	7

Зураг 6. Аймгийн төв дэх ус хангамжийн эх үүсвэрүүд.....	7
Зураг 7. Насос станцууд.....	9
Зураг 8. 2-р өргөлтийн насос станцын барилгын гадна тал болон станцын харагдах байдал.....	10
Зураг 9. 3-р өргөлтийн насос станцын барилгын гадна тал болон станцын харагдах байдал.....	10
Зураг 10. 2000 м ³ багтаамж бүхий өндрийн сан.....	10
Зураг 11. Цэвэр ус хэрэглэгчдэд дамжуулах шугам, ус түгээх байрууд	11
Зураг 12. Цэвэрлэх байгууламжуудын байршил.....	12
Зураг 13. Уурын зуухнууд, тэдгээрийн байршил	13
Зураг 14. Монгол орны физик газарүйн мужлал	14
Зураг 15. Төслийн талбайн орчны физик газарзүй, байрзүйн зураглал	15
Зураг 16. Монгол орны Байгалийн бүс, бүслүүр	15
Зураг 17. Төслийн талбай орчмын газрын гадаргын өндөржилт.....	16
Зураг 18. Газрын гадаргын налуужилт	17
Зураг 19. Мандалговь хотын агаарын температурын жилийн явц	17
Зураг 20. Мандалговь хотын хур тунадасны жилийн хуваарилагдал	18
Зураг 21. Салхины чиглэлийн давтагдал	19

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж

1.2. Төслийн зорилго

Дундговь аймгийн төвийн хүн ам, албан байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, дулаанаар хангах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

1.3. Төслийн хэрэгжүүлэгчийн нэр, хаяг

Төсөл хэрэгжүүлэгч	Дундговь-Ус ОНӨААТҮГ (Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн газар)
Улсын бүртгэлийн дугаар	0814001001
Регистрийн дугаар	3427951
Хаяг	Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг, Нарлаг 121-1, Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын байр
Утас	70593684, 98119780
E-mail	dundgovi.us@gmail.com

1.4. Төслийн үйл ажиллагааны чиглэл

Тусгай зөвшөөрлийн хүрээний үйл ажиллагааны чиглэл:


- Цэвэр ус олборлон түгээх, борлуулах, бохир ус татан зайлуулах.

Бусад үйл ажиллагааны чиглэл:

- Нийтийн халуун ус, дулаан үйлдвэрлэх, түгээх.

1.5. Төслийн байршил

Ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж төсөл нь Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт хэрэгждэг. Улаанбаатар хотоос баруун урд зүгт 350 км зайд байрлана. Умард говийн гүвээт – Халхын дундад талын сав газарт хамаарагдана.



Зураг 1. Төслийн байршил


1.6. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

Дундговь-Ус ОНӨААТҮГ нь Мандалговь хотын 1601 айл өрх, 163 аж ахуйн нэгж, байгууллагыг унд, ахуйн цэвэр усаар, 5 аж ахуйн нэгж, байгууллага, 235 айл, өрхийг дулаанаар ханган, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлдэг байна.

2022 онд 276,900 м³ ус олборлон, борлуулж, 2023 онд 307,000 м³ ус олборлон, борлуулахаар төлөвлөсөн.

Ус, дулаан, цэвэрлэх байгууламжууд нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

1. Ус хангамжийн эх үүсвэр – 2 ш (Олгойн говь, аймгий н төв)
2. Цэвэр ус дамжуулах шугам сүлжээ – 72.6 км
3. Бохир ус татан зайлуулах шугам сүлжээ - 11 км
4. Өргөх насос станц – 2ш
5. Даралтат усан сан -1ш
6. Ус түгээх байрууд – 17ш
7. Ус дамжуулах хоолой
8. Цэвэрлэх байгууламж
9. Уурын зуух



Зураг 2. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын төв байрны байршлын тойм зураг




Зураг 3. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын төв байрны орчны тойм зураг

Ус хангамжийн эх үүсвэр

Аймгийн төвийн ус хангамжийн 1-р эх үүсвэрийн 3 ширхэг гүний худаг сумын төвөөс 28-32 км-ийн зайтай Олгойн говь хэмээх нэртэй газарт, 2-р эх үүсвэрийн 3 ширхэг гүний худаг, 17 ширхэг ус түгээх байр нь сумын төвд байрладаг байна.

1-р эх үүсвэр (Олгойн говь) болон 2-р эх үүсвэрийн худгуудаас 4.5 км-ийн урттай, 110-160 мм-ийн голчтой хувцанцар хоолойгоор усыг цуглуулж, 2, 3-р өргөлтийн насос станцаар өргөн 250 м³-ийн багтаамжтай 1 ширхэг, 2000 м³-ийн багтаамжтай 1 ширхэг усан санд хуримтлуулж, 83.2 км-ийн урттай, 110-225 мм-ийн голчтой ус дамжуулах, түгээх хуванцар болон цайрдсан ган шугамаар хэрэглэгчдийг 24 цагийн турш усаар тасралтгүй хангана.

Ус хангамжийн 1-р эх үүсвэр нь аймгийн төвөөс 32 км зайд байрлалтай, гүний 3 худагтай боловч нэг худгийг нь ашигладаггүй, ашиглаж буй 2 худгийн улсын бүртгэлийн дугаар нь 9052, 9061. Эдгээр худгууд нь 1990 онд ашиглалтанд орсон бөгөөд 2007 онд АХБ-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн НАА-г хөгжүүлэх 2-р үе шатны төслийн хүрээнд тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн.



Зураг 4. Олгойн говьд байрлах ус хангамжийн эх үүсвэрүүд, тэдгээрийн байршил






Зураг 5. 1-р эх үүсвэр (Олгойн говь)

GRUNDFOS SP 49-19 QJ маркын насостой, автомат удирдлагын самбартай, цооногийн гүн 100, 114м, ундарга 5л/сек, ашиглалтын байдал хэвийн, эрүүл ахуйн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөөгүй, 1-р бүсийн хашаа хамгаалалттай. Энэ эх үүсвэрээс 11 дүгээр сарын 1-нээс 04 дүгээр сарын 01 хүртэл 2 худгийг ээлжлүүлэн ажиллуулж ус олборлодог. Насосны хүчин чадал нь 30м³/цаг, 195м –ын түрэлттэй. Олгойн говийн эх үүсвэрийн усны нөөцийг шинэчлэн тогтоох ажил хийгдэж 2014 оны 05 сарын 29-ний өдрийн БОНХЯамны Усны нөөцийн зөвлөлийн хурлаар тайлан мэдээ нь хэлэлцэгдэж хоногт 1100 тн ус ашиглахад 20 жилийн нөөцтэй гэж тогтоогдсон ба зөвлөмж дүгнэлтийг аваад одоо ашиглаж байна.

Ус хангамжийн 2-р эх үүсвэр нь аймгийн төвд байрлалтай бөгөөд гүний 3 худагтай, худгуудын улсын бүртгэлийн дугаар нь 6001, 6003, 5022. 6001, 6003-р худгууд нь 2005 онд 5022-р худаг нь 1984 онд ашиглалтанд орсон, тус бүр 3л/сек ундаргатай, цооногийн гүн 170м, QJ 156-20 маркын насостой. Тус эх үүсвэрээс 04 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 01 хүртэл гүний ус уолборлож даралтын усан сан болон төв шугамд шахалт хийдэг. Насосны хүчин чадал нь Q=20м³/цаг, түрэлт 156м.




Зураг 6. Аймгийн төв дэх ус хангамжийн эх үүсвэрүүд

Хүснэгт 1. Ус хангамжийн эх үүсвэрийн мэдээлэл

№	Цооногийн дугаар, байршил	Цооногийн гүн, м	Ундарга, л/с	Насосны марк	Тоолуурын марк	Ашиглалтанд орсон он	Өргөтгөл, шинэчлэл хийсэн он	Тайлбар
1	9061 (Олгойн говийн 1-р гүний худаг)	95	5	GRUNDFOSS	LXLG-80	1990	2014	Аймгийн төвөөс 28 км зайтай. Ашиглалтын байдал хэвийн.
2	9067 (Олгойн говийн 2-р гүний худаг)	71	6	ЭЦВ-6-6,3-125	LXLG-80	1988	2016	Аймгийн төвөөс 32 км зайтай. Ашиглалтын байдал хэвийн.
3	9066 (Олгойн говийн 3-р гүний худаг)	105	9			1987		Аймгийн төвөөс 30 км зайтай. Нүүрсний судал гарсан тул ашиглах боломжгүй болсон, ашиглагдахгүй байгаа
4	6001 (Аймгийн төв)	132	10	GRUNDFOSS	LXLG-80	2005	2015	Цооногийн шүүр муу хийгдсэнээс насос элс сордог, бүрэн хүчин чадлаар ажиллуулах боломжгүй. Ундны бус зориулалтаар ашиглаж байна. Газар эзэмших гэрчилгээ №0209355, хэмжээ 109 м ²
5	5222 (Аймгийн төв)	104	5	GRUNDFOS-SP46	OPTILUX	1980	2017	Гэр хорооллын айл өрхийн жорлон ойр байгаа тул ундны бус зориулалтаар ашиглаж байна. Газар эзэмших гэрчилгээ №0209355, хэмжээ 100 м ²
6	6003 (Аймгийн төв)	175	6	QJ хятад	OPTILUX	2005	2017	Ашиглалтын байдал хэвийн Газар эзэмших гэрчилгээ №0209354, хэмжээ 236 м ²

Ус дамжуулах 1-р өргөх насос станц нь аймгийн төвөөс 7.5 км-т байрлалтай, суурилагдсан тоног төхөөрөмж 2-р насос станцтай ижил.

Ус дамжуулах 2-р өргөх насос станц нь 1990 онд ашиглалтанд орсон, аймгийн төвөөс 27 км зайд байрладаг. 2007 онд НАА-н төслөөр тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн. GRUNDFOS NB 50-200/219 маркын $Q=90\text{м}^3/\text{цаг}$, $H=60\text{м}^3$ хүчин чадалтай 3 ширхэг насостай, 1 насос хоногт 7-8 цаг ажилладаг, 2 насос нөөцөнд байдаг. Гаргалгааны шугам дээр электрон соронзон тоолууртай, автомат удирдлагын самбартай, суурилагдсан хүчин чадал нь $270\text{м}^3/\text{цаг}$. 250м^3 -ын багтаамжтай ус нөөцлөх усан сантай, эрүүл ахуйн бүсийг хашаажуулсан. Резервуарын ам таглаа битүүмжлэл сайн, цоожтой, лацтай.



Зураг 7. Насос станцууд



Зураг 8. 2-р өргөлтийн насос станцын барилгын гадна тал болон станцын харагдах байдал



Зураг 9. 3-р өргөлтийн насос станцын барилгын гадна тал болон станцын харагдах байдал


Усан сан: Эх үүсвэрээс олборлосон усыг 2 өргөх насос станцаар дамжуулан 2000м³-ын ус нөөцлөх санд хуримтлуулж, 158 гаруй аж ахуй нэгж албан байгууллага, хотын 12421 хүн амыг хоногт дунджаар 900-1100м³ ахуйн хэрэглээний усаар 24 цагийн турш тасралтгүй хангана. Энэ усан сан нь төвөөс 2.1 км-т өндөрлөг газарт байрлалтай учир усыг өөрийн урсгалаар хэрэглэгчдэд хүргэдэг.



Зураг 10. 2000 м³ багтаамж бүхий өндрийн сан

Цэвэр усны шугам сүлжээ: Цэвэр ус дамжуулах гол шугам сүлжээний урт нийт 72.6 км. Олгойн говийн худаг хоорондын шугам сүлжээний урт 4.2 км, дм110, цуглуулах төв шугамын худагас аймгийн төв хүртэл 30 км урттай хос 225-ын хуванцар хоолойтой, аймгийн төв дээр кольцо төв шугамын урт 2.7 км, гэр хорооллын төв шугамын урт 5.7 км. Эдгээр шугам нь 100 хувь хуванцар хоолойгоор шинэчлэгдсэн. Цэвэр усны төв шугамын худгийн тоо-87, хоолойн дм 110-225мм. Байгууллагын харъяаны цэвэр ус түгээх /салбар/ шугамын нийт урт 14.4 км. Түгээх шугамын худгийн тоо-203, хоолойн дм 20-150мм.


Ус түгээх байрууд: Төвийн шугаманд холбогдсон гэр хорооллын 17 ухаалаг худгуудаар стандартад нийцсэн цэвэр усыг 24 цагаар түгээж, тэдгээрийн инженерийн шугам сүлжээний засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийн ажиллаж байна.



Зураг 11. Цэвэр ус хэрэглэгчдэд дамжуулах шугам, ус түгээх байрууд

Цэвэрлэх байгууламжууд: Хуучин цэвэрлэх байгууламж нь аймгийн төвийн суурьшлын бүсэд байрлах ба 1978 онд ашиглалтад орсон. Механик цэвэрлэгээтэй, хүчин чадал нь 1400 м³/хон. Автомат сараалж нь эвдэрсэн тул гар аргаар цэвэрлэдэг байсан. Элс зайлуулах гидроэлеваторын систем нь анхнаасаа ажиллаагүй, шууд тунгаагуурлуу өгдөг. 4 тунгаагуурын 2 нь ажиллаж байсан. Босоо тунгаагууруудын хөрс суулт өгснөөс эвдэрч гажсан, шүүх талбайн ус цуглуулах шугамууд битүүрснээс шүүрэлт явагдахгүй болж далан байнга сэтэрдэг байсан. Цэвэрлэгээний түвшин нь 10%-тай, бохир усыг шууд шүүх талбай руу хаядаг. Ариутгалын төхөөрөмж анхнаасаа хийгдээгүй. Лаг боловсруулах төхөөрөмж байхгүй учир лагийн талбай руу шууд хаядаг байжээ. 2017 оны 07-р сарын 17-ны өдрийн 13-03-025/100 дугаартай Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтээс харахад тус цэвэрлэх байгууламж нь механик болон биологи цэвэрлэгээ огт хийхгүйгээр бохир усыг шууд хүрээлэн буй орчинд хаяж, хөрс орчныг бохирдуулж байгаа төдийгүй хүн амын дунд гэдэсний халдварт өвчин, халдварт шар өвчин голомтлон гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж дүгнэлт гарсан тул Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хоногт 3000м³ хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж байгуулан ашиглалтанд оруулсан байна. Цэвэрлэх байгууламж

ашиглалтанд орсноос хойш цэвэрлэгдсэн уснаас 2023 оны 3-р сард холимог дээж авч магадлан итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэхэд 97.1% хүртэл цэвэршилтийн түвшинтэй байсан байна.



Зураг 12. Цэвэрлэх байгууламжуудын байршил

Ариутгах татуургын шугам сүлжээ: Бохир усны цуглуулах шугам сүлжээний урт 11 км. Худгийн тоо-310. Орон сууцны ОО түвшингээс, хэрэглэгчдийн анхны худгаас цааш манай байгууллага ашиглалтыг хариуцдаг. Хоолойн дм100-200мм. Вааран, ширмэн, PVC -U хоолойтой. Бохир усны татан зайлуулах шугам сүлжээний урт 8 км. Худгийн тоо-109 ширхэг, хоолойн дм 200-350мм. Хотын төв, баруун, зүүн гэсэн 3 чиглэлээр төв шугам байрладаг. Вааран, ширмэн хоолойтой. Суулгалтын гүн 2.3-7.5 м.

Аймгийн төвд бохир усны төвлөрсөн шугамд холбогдох боломжгүй байрлалтай 49 хэрэглэгчийн бохир усны цооногоос бохир ус тээвэрлэх тусгай зориулалтын машинаар бохир зөөвөрлөж үйлчилдэг.

Дулаан хангамж: Дундговь-Ус ОНӨААТҮГ нь “Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах” тусгай зөвшөөрлийн хүрээнд халаалтын улиралд

аймгийн төвийн 31449.6 м³ эзэлхүүн бүхий 277 айл өрх, 4 аж ахуй нэгж, 5 төсөвт байгууллагыг дулаанаар хангадаг. Үүнд нийтийн эзэмшлийн болон хувийн орон сууцны айл өрх, төв спорт заал, төрөх эмнэлэг, мөн халуун усны өөрийн дотоод хэрэглээ, конторын зуухны орчны айлын хувийн орон сууц, захиргааны гараж, тагнуулын хэлтэс ордог. Хэрэглэгчийн 97% нь орон сууцны айл өрх, 3% нь аж ахуй нэгж, төсөвт байгууллага байдаг. Хэрэглэгчдийг тусгай зөвшөөрлийн дагуу дулаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулж дулаанаар хангаж ажилладаг.




Зураг 13. Уурын зуухнууд, тэдгээрийн байршил

Нийтийн халуун усны газар нь 2014 онд 111 сая төгрөгний засвар, шинэчлэлтийн ажил хийгдэж одоогоор нэг ээлжиндээ 21 хүн хүлээж авах хүчин чадалтай ажиллаж байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Физик газарзүйн нөхцөл

Төсөл хэрэгжих талбай нь Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт 32 км үргэлжилнэ. Тус талбайн ихэнх хэсэг нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн баруун хэсэгт буюу Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт хойноос урагш чиглэлтэй орших бол багахан хэсэг нь Дорнод говийн мужийн Умард говийн Ухаа толгодот талын хойд хэсэгт хамаарна. Судалгааны талбайн уртын дагууд ухаа гүвээт бэсрэг толгодтой тал зонхилон үргэлжилнэ.




Зураг 14. Монгол орны физик газарзүйн мужлал

Халхын дундад ухаа гүвээт талын тойрог: Дорнод Монголын уужим тэнүүн тэгш тал, ухаа гүвээрхэг газрыг хамаарна. Газрын гадаргын байдлаараа нэгэн жигд учраас ургамалжилтын хувьд ч мөн тийм байдаг. Тухайлбал: Сибирь хялгана, Криловын хялгана, Нангиад түнгэ, Дэрвээн хазааргана, Саман дурваа, Сунагар биелэг, Баллисийн ботууль, Саман ерхөг зэрэг үетэн оролцсон Хялгана-Дурваат, Шивээт хялгана-шавагт, Шивээт хялгана-хазаарганат, Түнгэ-Шивээт хялганат хуурай хээр зонхилно. Хээрийн судалгааны явцад энэ тойргийн үндсэн төрхийг үзүүлэх ургамлуудаас *Elymus chinensis*-Хиаг, *Potentilla leucophylla*-Цагаан навчит гичгэнэ, *Caragana stenophylla*-Нарийн навчит харгана зэрэг зүйлүүд бүртгэгдсэн.


Дорнод говийн мужийн Умард говийн ухаа толгодот талын тойргийн баруун хэсэгт хээрийн судалгаа хийсэн талбайн зүүн тал нь оршино. Энэ хэсэгт сунаж

тогтсон ухаа гүвээ, элсэн хуримтлалтай довцог, хуурай сайр бүхий цөлөрхөг хээрийн бүс зонхилно. Судалгаа хийсэн талбай нь агаарын температурын хэлбэлзэл ихтэй, хуурай нутаг юм. Иймд шугам хоолойн дагууд хайлаас, заг зэрэг модлог ургамал таараагүй бөгөөд газрын гадарга нь ургамлан бүрхэц багатай, хад чулуурхаг, сайр, жалга ихтэй, элсэн хуримтлал бүхий довцог, сондуул их тааралдсан болно.




Зураг 15. Төслийн талбайн орчны физик газарзүй, байрзүйн зураглал

Байгалийн бүс, бүслүүрийн хувьд төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүсэд хамаарна (Н.Өлзийхутаг (1989)).




Зураг 16. Монгол орны Байгалийн бүс, бүслүүр

Монгол улс хамгийн нам доор газраа далайн түвшнээс дээш 560 м-т, хамгийн өндөр нь 4374м өндөрт өргөгдсөн харьцангуй өндөрлөг газар оршдог орон юм. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1340-1480 метрийн өндөрт оршиж байна. Энэ нь Монгол орны дундаж (1580 м) өндрөөс нам дор байна. Олгойн говийн эх үүсвэрээс баруун урд зүгт 2.3 км орчим зайд байх Зүрх толгой нь 1344 метрийн өндөрт буюу тухайн орчиндоо хамгийн өндөрлөг нь байна. Насос станцаас баруун зүгт 4 орчим км-т Цагаан толгой 1444 м, зүүн хойд зүгт 5 орчим км-т Баруун шанд уул 1525 м өндөрт байршиж байна. Шинэ цэвэрлэх байгууламж 1353 м өндөрт, аймгийн төвд байх түгээх байр болон уурын зуухнууд 1348-1401 м өндөрт байршиж байна.



Зураг 17. Төслийн талбай орчмын газрын гадаргын өндөржилт

Газрын гадаргын налуугаас хамааран хүчтэй аадар борооны үер болон шар усны үер, уулын нуранга, шугаман эвдрэл болон угаагдал зэрэг усны үйл явцаар эвдрэл элэгдэл үүсдэг. Газрын гадаргын налуужилт нь хөрсний элэгдэл эвдрэлд нөлөөлөөд зогсохгүй газар ашиглалтад чухал нөлөө үзүүлдэг. Гадаргын налуугийн хувьд шугам хоолой, цэвэрлэх байгууламж, ус түгээх байрууд нь 0-4 градусын налуу бүхий газар байршиж байна. 0-4 градусын налуу нь тариалан, хадлан, хот суурин зэрэг газар ашиглалтад тохиромжтой байдаг.




Зураг 18. Газрын гадаргын налуужилт

2.2. Уур амьсгалын нөхцөл

Агаарын температур: Сүүлийн 80 шахам жилийн дотор Монгол орны нутаг дэвсгэр дээрх жилийн дундаж агаарын температур 2.4 градусаар дулаарчээ. Энэ нь дэлхийн дунджаас даруй 3 дахин эрчтэй дулаарч байна. Тус сумын нутагт жилийн дундаж агаарын температур 2.6 градус дулаан байна.

Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар бөгөөд, агаарын дундаж температур -17°C , хамгийн их температур 4.1°C , хамгийн бага температур -38.3°C , хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд агаарын дундаж температур 20.8°C , хамгийн их температур 39.6°C , хамгийн бага температур 1.5°C байдаг.



Зураг 19. Мандалговь хотын агаарын температурын жилийн явц

Агаарын чийг, хур тунадас: Аймгийн нутгаар дундажлаж үзвэл энэ нутагт жилдээ дунджаар 23.8-66.7 мм хур тунадас унадаг бол Мандалговь хотод олон жилийн

дундаж нь 136.8 мм байдаг байна.

Энэ хэмжээ нь бүс нутагтаа багагүйд тооцогдоно. Гэхдээ дулаан улиралд хур тунадасны 92-93% нь шингэн буюу бороо хэлбэрээр, шилжилтийн улирал буюу 4 ба 10 дугаар сард нойтон цас (цас, бороо холилдон орох) хэлбэртэй, үлдсэн 7-8 % нь хүйтэн улирлын 11-3 дугаар сард дан цас хэлбэртэй орно. Зуны 6-8 дугаар сарын бороо нь аж ахуйн үйл ажиллагаанд заримдаа хэд хэдэн цагаар саатал гаргаж байдаг ч нөгөө талаар орчны бохирдолтыг багасгаж тоос шороог тодорхой хэмжээгээр дарж өгдөг. Зуны хур тунадас ялангуяа богино хугацаанд орсон их хур тунадас гадаргын усны болон хөрсний чийгийг нэмэгдүүлнэ. Нэг хоногт ордог тунадасны хэмжээ зарим жил сард ордог хур тунадасны хэмжээнээс давах тохиолдол бий. 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо 112 өдөр байна.


Хамгийн анхны цас олон жилийн дунджаар 9 сарын 4-өөс 10 сарын 27-н хооронд, эцсийн цас 3 сарын 16-наас 6 сарын 2-ны хооронд ажиглагддаг. Жилийн 27 хоног цасан бүрхүүлтэй байдаг.

Тус аймагт жилд дунджаар 11 удаа цасан шуурга ажиглагдана. Цасан шуургатай өдөр нэмэгдэж байгаа нь хаврын улиралд агаарын температурын хэлбэлзэл ихтэй байдгаас зарим жил 5 дугаар сард цас орж цасан шуурга шуурч байсан байна. Судалгаанаас хархад 2010 онд хамгийн их тохиолдол нь Мандалговьд 54 удаа ажиглагдсан байна.

Мандалговь хотын хур тунадасны олон жилийн дундаж утгын үзүүлэлтийг Хүснэгт 1.2-д харуулав.

Хүснэгт 2. Мандалговь хотын хур тунадасны үзүүлэлт

I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын нийлбэр, мм											
1.2	1.3	2.3	4.9	8.8	21	41.6	39.8	8.7	3.8	2.1	1.4
Хоногийн хамгийн их, мм											
2.5	4.2	5.0	11.7	17.3	28.6	41.2	39.7	19.2	17.6	4.9	3.9



Зураг 20. Мандалговь хотын хур тунадасны жилийн хуваарилагдал

Салхи: Тус аймгийн нутаг бүхэлдээ салхи ихтэй нутагт хамрагдах бөгөөд жилийн салхины дундаж хурд нь 3.1-6.1 м/с-ийн хооронд хэлбэлзэнэ. Салхины хурд нь тухайн орон нутгийн хотгор гүдгэрийн байдлаас ихээхэн шалтгаалдаг.

Ажиглалтын материалаас үзвэл тус сумын нутаг хамгийн их салхитай нутагт орж байна. Энд салхины дундаж хурд 5.1-6.1 м/с байдаг ба 4-5 саруудад салхины хурд 6.2-6.8 м/с хүрдэг байна. Тус сумын нутаг нь манай орны бусад нутгийн нэгэн адил хойд, баруун хойд, баруун зүгийн салхи голчлон давтагддаг.


Салхины дундаж ба хамгийн их хурдны утгыг Хүснэгт 1.3-д, салхины чиглэлийн

давтагдалыг Хүснэгт 1.4 болон Зураг 17-д үзүүлэв.

Хүснэгт 3. Мандалговь хотын салхины үзүүлэлт

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Салхины дундаж хурд, м/с	4.1	4.2	4.6	5.7	5.9	4.9	4.1	3.7	3.9	3.7	4.0	3.9
Их хурд, м/с	24	24	30	34	34	24	20	20	20	24	24	24


Доорх зургаас үзэхэд тус бүс нутагт баруун, баруун хойд зүгийн салхи зонхилдог болох нь харагдаж байна. Тухайн орон нутгийн хотгор гүдгэрээс хамаарч салхины чиглэлийн давтагдал харилцан адилгүй байна.



Зураг 21. Салхины чиглэлийн давтагдал

Шороон шуурга хаврын өдрүүдэд тасралтгүй болдог. Тэгэхдээ 6м/с-ээс салхи хэтрэхлээр явган шороон шуурга, 12-15м/с түүнээс дээш салхитай болохлоор намын шороон шуурга болно. Энэ нутагт хөрс, ургамал эмзэг, харьцангуй хожуу цас орж хавар эрт арилж, бороо хур элбэг бишээс хөрсний чийг хомс учир шороон шуурга болох магадлал харьцангуй их юм.


Тус аймагт жилд дунджаар 7-8 өдөр шороон шуургатай байдаг бөгөөд энэ нь гол төлөв хавар 3-5 дугаар сард ажиглагддаг. Энэ нь хөрсний элэгдэл, элс, шорооны зөөгдлөөс хамаарч салхины хурд нэмэгдэх төдийд их хэмжээний тоос шороо босч алсын барааг муутгаж байгаа нь хүний хүчин зүйлс, хот суурингийн хэт төвлөрөлтөөс их хамаарч байна.



Зураг 1. Мандалговь хотын шороон шуургатай өдрийн тоо /сараар/

2.3. Гадаргын ус

Дундговь аймгийн Сайнцагаан сум Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт багтана. Тухайн бүс нутагт томоохон гадаргын урсац байхгүй. 2018 оны гадаргын усны тоо бүртгэлээр Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт 12 булаг бүртгэгдсэн байна. Төсөл хэрэгжиж буй талбайд хамгийн ойр орших булгуудаас Хувын булаг 12.4 км, Их булаг 15.4 км, Хоолойн гашуун булаг 13.3 км, Зүлэгтийн булаг 15.1 км орчим зайтай байна.



Зураг 2. Гадаргын усан сүлжээ

2.4. Газрын доорх ус

Дундговь аймгийн нутгийг хамарсан газрын доорх усны сав газрууд геологийн тогтцын хувьд Дундад халхын болон Төв Монголын өргөгдлийн бүсэд байрладаг учраас ренажид хүчтэй орсон ан цавлаг, нүх сүвэрхэг боловч хуурай ус багатай магни, кальцийн

агуулга харьцангуй өндөр зэрэг онцлогуудтай. Энд чөлөөт гадрагатай буюу грунтын ус, даралтад ус аль аль нь тааралддаг бөгөөд чөлөөт гадаргат ус 3-30 м гүний хооронд, даралтад ус нь 8.5-168 м гүний хооронд байрладаг. Усны хөөрсөн даралт 170 м хүрч, усны шавхалтын дүнгээр ундрага 1-23 л/с хооронд, хувийн ундрага 0.003-7.7 л/с хооронд тус тус хэлбэлздэг байна.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар нь Чойрын, Дөрвөлжин овоотын, Мандалговийн, Өлзийтийн, Загийн усны хоолойн, Эрдэнэдалайн, Бөөрөлжүүтийн, Цайдам нуурын, Мөнххааны хэмээн 9 сав газарт хуваан гидрогеологийн нөхцлийг тодорхойлж газрын доорх усны нөөцийг тооцсон байна. Мандалговь, Өлзийт, Загийн усны хоолойн газрын доорхи усны савууд нь нуурын гаралтай хурдас дахь ус агуулагч үе, тунамал сэвсгэрдүү хурдас дахь ус агуулагч бүрдэл, Тунамал чулуулаг дахь ус агуулагч давхраадаст, ан цавлаг бүрдэл, тунамал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс, янз бүрийн насны түрмэл бялхмал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүсүүд тус тус тархсан гидрогеологийн нөхцөлтэй.

Аймгийн төвийн ус хангамжийн төвлөрсөн найдвартай эх үүсвэрийн олох зорилгоор их хэмжээний эрэл хайгуулын ажлыг Н.Лхагва удирдан нилээд хэдэн жил явуулсаны үр дүнд Олгойн говийн газар доорхи усны ордуудыг илрүүлсэн. Олгойн говийн газрын доорхи ус нь доод цэрдийн настай, намгархаг эх газрын гаралтай хурдас дахь ус юм. 1985-1986 онд Олгойн говийн цэвэр усны эх үүсвэрийн хайгуул хийгдэж, аймгийн төвийн усны хоногийн хэрэглээг 2750 м³/хоногоор тооцож 15 жил ашиглах нөөцтэй гэж тогтоогдсон юм.

2012-2014 онд Олгойн говийн ундны усны эх үүсвэрийн нөөцийг шинэчилэн тогтоох ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Байгаль Орчны Яамны шугамаар хийгдэж, Усны нөөцийн зөвлөлийн хурлаар тайлан мэдээ нь хэлэлцэж 1100 м³/хоног ус олборлоход 15 жилийн нөөцтэй болох нь тогтоогдсон.

2004-2005 онд Чех улсын буцалтгүй тусламжаар аймгийн төвд 2 гүний худаг шинээр гаргаж, хуучин ашиглаж байсан худагт технологийн шинэчлэлт хийснээр ундны усны 2 эх үүсвэрээс усыг улирлын чанартай ээлжлэн олборлож газрын доорх усны баланс барих боломж бүрдсэн.

2.5. Хөрсөн бүрхэвч

Сайнцагаан сумын нутаг дэвсгэр, аймгийн төв орчмын газар нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын их мужуудын Говийн их мужийн Дундговийн тойрогт хамаарагдана.

Дундговь-Ус ОНӨҮГ-ын объектууд нь суурьшлын бүсэд ихэнх нь байрлах ба усны эх үүсвэр болон өндрийн сан, насос станцууд нь Сайнцагаан сумын Тэвш багийн нутагт сумын төвөөс чанх баруун хойно хамгийн хол нь 28-32 км зайд байрлана. Энэ хэсэгт тэгш талархаг гадаргатай, ургамлын бүрхэц 11%, шарилж-дэрст бүлгэмдэлтэй, чулуурхаг сайргархаг бүрхэвч 70%, гадаргын налуу 0-0.1°, элсэнцэр цайвар хүрэн тархсан байна. Суурьшлын бүсэд толгодын цайвар хүрэн хөрс тархана. Цайвар хүрэн хөрсний онцлог нь тал хөндийн хөрсний бүлэгт хамаарагдах ба ургамлын бүрхэц дунджаар 20-30% буюу бага. Иймд салхины үлээгдэлд хялбар өртөж, том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг. Хур тунадасны ус энэ хэв шинжийн хөрсөнд 15-20 см гүн буюу нэвчиж хөрсний зөвхөн өнгөн хэсгийг чийглэдэг. Үржил шимээр бага, шим тэжээлийн бодисын хангамж муутай, хөрсний 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 30-40 тн/га, азотын хэмжээ 3 тн/га орчим байдаг. Мөн цайвар хүрэн хөрсний урвалын орчин хөрсний бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй, ялангуяа доод

давхаргуудад илүү шүлтлэг байдаг. 2019 онд хийсэн судалгааны хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд хөрсний ялзмагийн агууламж нийт дээжинд (1-0.337%) болж дээд үеэс доод үерүү буурсан байна. Дээрх хөрсний орших районд хөрсний дээд үеийн ялзмагжилт 0.8-1.0%-ийн хооронд байдаг байна. Хөрсний урвалын орчин дээд үеэс доод тогтмол сул шүлтлэг. Энэ нь тэр хөрсний шингээх бүрдэлдэх натрийн катионтой буюу карбонат натрийн (Na_2CO_3) шүлтлэг урвалтай холбоотой.

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөн удаан хугацаанд хадгалагдаж усаар, агаарын тоосонцороор дамжин мал, амьтан, хүний бие организмыг хордуулдаг. Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн хэсэг байрлах байршлуудад 2019 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хяналт шинжилгээгээр “MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-ний үзүүлэлтээс давсан бохирдолд илрээгүй.

Суурьшлын бүсийн хөрс нь антропогений нөлөөгөөр хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн гадаргын ургамалжилт устаж үгүй болсон, хөл газрын хог ургамлаар бүрхэгдсэн.

2.6. Ургамлан нөмрөг

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг дэвсгэр Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Дундад халхын хээрийн тойрогт⁴ хамаарна. Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн ангиллаар цөлөрхөг хээрийн бүсэд орно. Цөлөрхөг хээрийн бүс нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж буй болсон, биеэ даасан үүсэлтэй, зөвхөн энэ бүсэд ургадаг зонхилогч ургамлуудтай байдгаараа онцлог. Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын харъяанд байдаг цэвэрлэх байгууламж, эх үүсвэрийн худаг, ус түгээх байр, уурын зуух зэрэг объект орчмын ургамалжлын төлөв байдлын хувьд талбайд хөл газрын Ишгэн шарилж, Адамсийн шарилж, Цагаан лууль, Шоргор лууль зэрэг ургамлууд зонхилогчийн үүрэгтэй оролцож, ургамал бүлгэмдлийг тодорхойлогч болно. Энд талхлагдлын узаагуур ургамлууд зонхилж байдаг тул тусгагийн бүрхэц 35-47%, зарим ургамал багатай жижиг талбайтай газарт 5-15% байхад халцгай газрын хэмжээ 10-40% хүрнэ. Хагд өвс бараг хадаглагдахгүй. Ихэнхдээ халцгай газар тааралдаж, ургамал бүлгэмдэл хашаа, байшингийн ёроолоор хэсгээр багахан талбайд тааралдана. Энд хүний болон техникийн нөлөөнөөс маш их хамааралтай.

Харин Олгойн говийн усны эх үүсвэр, насос станц 1, 2 болон өндрийн сангийн худаг зэрэг усны эх үүсвэрүүдтэй талбай хүний болон малын нөлөөнд өртөмгийг байна. Өндрийн сангийн худагас бусад талбай суурин газраас хол байрладаг тул байгалийн унаган төрхөө харьцангуй бага алдаж, ургамал бүлгэмдлийн зонхилогч зүйлүүд нь дэрс, дэлхээ тогторгоно, сайрын хялгана, харгана зэрэг цөлөрхөг хээрийн шинжийг илтгэгч олон наст өвслөг ургамлууд байна. Эдгээр усны эх үүсвэрүүдийг хашиж хамгаалснаар сайрын хялгана, дэрс зэрэг ургамлууд давхар хамгаалагдаж, ургамал бүлгэмдлийг тодорхойлогч болж байхад, хашааны гаднах талбайд тааралдахгүй юмуу эсвэл бүлгэмдэл үүсгэж чадахгүй болжээ. Хагд өвсний хэмжээ харьцангуй багатай. Хагд өвс хөрсийг халалт, хөлдөлт зэргээс хамгаалахаас гадна, хавар, өвлийн цагт малын тэжээл болдог ач холбогдолтой.

2.7. Амьтны аймаг

Аймгийн төв орчмын нутаг дэвсгэрийн үндсэн амьтны аймгийн төрөл зүйл нь үргэн дайжсан, хотжилтын нөлөөнд өртсөн тул суурин газарт үзэгдэх зарим зүйлийн шувуу, мөлхөгчид тааралдана. Харин олгойн говийн эх үүсвэр болон дамжуулах станц,

өндрийн сангийн орчимд зарим зүйлийн шувууд үзэгдэнэ. Тухайлбал говийн ногтруу (*Syrhaptes paradoxus*), Хондон ангир, (*Tadorna ferruginea*), Шоорон эвэрт болжмор, (*Eremophila alpestris*), Банхар булжуухай (*Coccothraustes coccothraustes*), Гэээгт шумбуур (*Aythya fuligula*), Хон хэрээ (*Corvus corax*), Шилийн сар (*Buteo hemilasius*) гэсэн 6 төрлийн 7 зүйл шувуу тохиолдсон. Эдгээр 7 зүйл шувууд нь “Монгол орны шувууны улаан данс (2011)”-ны Бүс нутгийн болон Олон улсын үнэлгээгээр “Анхааралд өртөхөөргүй” статустай, өргөн тархацтай элбэг зүйлүүд юм.

2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг

Дундговь аймгийн төвийн хүн амын ундны усны эх үүсвэр байрлаж буй Олгойн говийн 1, 2-р хэсэг буюу 6657.25 га газрыг Дундговь аймгийн ИТХ-ийн 2016 оны 01 сарын 29 өдрийн 15 тоот тогтоолоор усны нөөц газрын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар аймгийн тусгай хамгаалалтанд авсан.

2.9. Нийгэм эдийн засгийн байдал

Дундговь аймгийн Сайнцагаан суманд 2022 оны жилийн эцсийн байдлаар 15716 хүн ам амьдарч байгаагаас эрэгтэй 7540, эмэгтэйчүүд 8176 байна. 8Оны эхний хөдөлмөрийн насны хүн амын тоо 10057, үүнээс тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд 92, тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүдийн тоо 115, хөдөлмөрийн насны 10000 хүн тутамд ноогдох ажилгүйчүүдийн тоо 114 байна. Мөн оны нэгдсэн дүнгээр орон нутгийн төсвийн орлого 831212.7 мян.төг буюу орлогын төлөвлөгөөний биелэлт 107.5%-тай гарчээ. Газар өмчлөх тухай хүсэлт гаргасан иргэдийн тоо 227, Засаг даргын захирамжаар газар өмчлүүлэх шийдвэрлэлтийн биелэлт 100%, өмчлүүлсэн газрын хэмжээ нийт 16.2 га байна. 2019 оны мал тооллогын дүнгээр сумын хэмжээнд 417543 мал тоологдсоноос сүргийн бүтцээр тэмээ 1306, адуу 19689, үхэр 6285, хонь 196020, ямаа 194243 байна. Малчин өрхийн тоо 831, малтай өрхийн тоо 1016, мал бүхий нэг өрхөд ноогдох малын тоо дунджаар 411, малчин нэг өрхөд ноогдох малын тоо 502 байна. Газар тариалангийн үзүүлэлт нь тариалсан нийт талбайн хэмжээ 7.4 га буюу үүнээс төмс 5.5 га, хүнсний ногоо 1.9 га-д тариалалт хийжээ. Ургац хураалт 108.1 тн байгаагаас төмс 69.8 тн, хүнсний ногоо 38.3 тн хурааж, бэлтгэсэн гар тэжээл 152 тн байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга: Аймгийн төв дотор орших усны эх үүсвэр, усан сан, ус түгээх цэгүүд, халаалтын хэсэг, цэвэрлэх байгууламж, шугам сүлжээний хэмжээгээр газрын гадарга элэгдэл эвдрэлд орсон. Цаашид ч энэ нөлөө үргэлжлэх болно. Харин Олгойн говьд байрлах эх үүсвэрийн хэсгийн газрын гадаргын элэгдэл эвдрэл бага байна.

Уур амьсгал: Төслийн үйл ажиллагаанаас уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөө үзүүлэхгүй.

Агаарын чанар: Дундговь аймгийн Сайнцагаан сум нь төвлөрсөн халаалтын эх үүсвэр байхгүй, олон жижиг эх үүсвэрүүд жил бүрийн 10 сараас 04 сарыг дуустал ажилладаг. Халаалтанд түүхий нүүрсийг шууд хэрэглэж байгаа нь өвлийн саруудад аймгийн төвийн агаарын чанарт шууд нөлөөлж байна.

Гадаргын ус: Аймгийн төвийн суурьшлийн бүс болон Олгойн говийн эх үүсвэрийн ойр орчимд байнгын урсгалтай гадаргын ус, нуур байхгүй тул гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй.

Газрын доорх ус: Аймгийн төвийн хэрэглэгчдэд түгээж буй цэвэр усыг өвлийн саруудад Олгойн говь, дулааны саруудад аймгийн төв доторх эх үүсвэрээс олборлон түгээдэг тул усны нөөцөд шууд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Мөн шугам сүлжээний алдагдал, хэрэглэгчдийн зүй бус хэрэглээ зэрэг нь нөөцөд дам байдлаар нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвч: Аймгийн төвийн суурьшлийн бүсэд орших байгууллагын харьяаны объектуудын хэмжээнд хөрсний төлөв байдал нь хотжилтын нөлөөнд өртсөн. Харин Олгойн говьд байрлах цэвэр усны эх үүсвэрийн орчмын хөрсөн бүрхэвч нь элэгдэл эвдрэл бага, байгалийн төрх байдлаараа байна.

Ургамлан нөмрөг: Олгойн говьд орших цэвэр усны эх үүсвэрийн дэвсгэрт нутагт “Цэвэр усны нөөц газар”-ын зориулалтаар орон нутгийн тусгай хамгаалалтад авч, эх үүсвэр тус бүрийг хашаажуулсан. Энэ эх үүсвэр орчмын ургамлан нөмрөгийн нөлөөлөлд өртсөн байдал бага, байнгын харуул хамгаалалттай байдаг. Харин аймгийн төв доторх усан сан, ус түгээх цэг, цэвэрлэх байгууламж, халаалтын хэсгүүд, бусад объект байрлах газрын үндсэн ургамлын төрөл зүйл өөрчлөгдөж, сөрөг нөлөөлөлд өртсөн, цаашид ч энэ байдал үргэлжлэх болно.

Амьтны аймаг: Тухайн бүс нутгийн үндсэн амьтны аймгийн төрөл зүйл нь үргэн дайжиж, хотжилтын нөлөөнд өртсөн тул амьтны аймагт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл бага.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Олгойн говьд орших цэвэр усны эх үүсвэрийн 1,2-р хэсгийг “цэвэр усны нөөц газар”-ын зориулалтаар орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нь нь зориулалтын дагуу гэж үзнэ.

Нийгэм эдийн засгийн байдал: “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь аймгийн төвийн хэрэглэгчид (хүн ам, албан байгууллага, аж ахуй нэгж)-ийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх, хэсэгчилсэн дулаанаар хангах үйлчилгээг үзүүлдэг орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллага тул иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлд нийгэм эдийн засгийн талаасаа эерэг нөлөө үзүүлнэ.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын “Ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2018 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсрууллаа.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт үүсгэж буй тоосжилт, хөрсний элэгдэл, доройтол, ургамлан нөмрөгийн доройтол, газрын доорх усны нөөц, хатуу шингэн хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 7,928,900,0 (долоон сая есөн зуун хорин найман мянган есөн зуун) төгрөг төлөвлөлөө.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилга, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	10
1		Яндангийн утаа шүүгчийн засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төсөл хэрэгжих орчимд	ш	-	2	Үйл ажиллагааны урсгал зардалд хамаарна.	Тогтмол	MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2	Уурын зуухнаас агаарт хорт хий ялгарах	Уурын зуухны үнс баригч төхөөрөмжийн ёроолд тунасан үнсийг өдөр бүр зайлуулж, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх	Ажлын байр, гадна талбай	тн	-	-	Төслийн өдөр тутмын үйл ажиллагааны зардалд орно.	Тогтмол	
3	Усны эх үүсвэрийн бүсийг бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бохирдохоос сэргийлэх	Эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хаягжуулалт, тэмдэгжүүлэлт хийх	-	-	-	-	Үйл ажиллагааны урсгал зардалд хамаарна.	2023 онд	✓ Усны тухай хууль ✓ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль ✓ Татварын тухай хууль ✓ Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний
4	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Усны тухай хуулийн 28.7-т заасны дагуу усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулах,	-	-	-	-	-	2023 оны 1-р улиралд	
5		Усны тухай хуулийн 29.1-т заасны дагуу	-	-	-	-	-	2023 оны 1-р улиралд	

		усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах							өдрийн 326, 327 дугаар тогтоол,
6		Хаягдал усны дүгнэлтэнд үндэслэн Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газраас хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах	-	-	-	-	-	2023 оны 1-р улиралд	
7		Усны нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар тооцсон усны төлбөрийг оруулав				2,948.9	Гэрээгээр тогтоосон хугацаанд (Ус ашиглалтын гэрээг дүгнэсэн актад тусгадсан төлбөрийг төлнө.)	
Нийт дүн						2,948.9		-	-

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Тэрбум мод хөтөлбөр”-ийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт тарьж ургуулсан мод, зүлэг, ногоон байгууламжийн усалгааг тогтмол хийхээр төлөвлөлөө.

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод, зүлэг, ногоон байгууламжийн усалгааг хийх	га	0.5	-	2600.0	2023 оны 5-10 сард	<ul style="list-style-type: none"> ✓ “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008 ✓ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 ✓ Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал		-	-	-	2600.0	-	-

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Ажилчдын болзошгүй осол аваараас сэргийлэх мэдлэг чадвар дутмаг байдлаас шалтгаалж осол аваар гарах, ослын нөхцөл хүндрэх	Ажлын байран дахь ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулах	1 удаа	500.0	1	500.0	2023 оны 2-р улиралд	<ul style="list-style-type: none"> ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
2	Хамгаалах хувцас хэрэгсэл хангалтгүй байх, хэрэглэж хэвшээгүйгээс шалтгаалж осол аваар гарах	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр (тоос шүүх маск, чихний аппарат, хамгаалалтын малгай, бээлий, тусгай зориулалтын хувцас) бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх					тогтмол	<ul style="list-style-type: none"> ✓ Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага MNS 6231 : 2011 ✓ Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал MNS 4931 : 2000 ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага MNS ISO 13688 : 2000
3	Ослын нөхцөл хүндрэх	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах					тогтмол	-
4	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж					тогтмол	<ul style="list-style-type: none"> ✓ Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
		хэрэгслүүдийн бүрдлийг хангаж, галын хорыг цэнэглэх						<ul style="list-style-type: none"> ✓ Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244 : 1994 ✓ Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал MNS 4284:2017
Нийт дүн			-	-	-	500.0	-	-

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Ахуйн	Хогийн цэгүүд болон тухайн орчны газрыг тогтмол ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авах	Үйл ажиллагааны хүрээнд	-	-	-	-	Тухай бүр	Хог хаягдлын тухай хууль, 2017 он
2		Ахуйн хог хаягдлыг зохих зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр тээвэрлүүлэх	Үйл ажиллагааны хүрээнд	сар	50,0	12	600,0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль -10.2.4. MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага. Сумын ИТХ-ын 2018.12.19-ний 07 тогтоол.
3	Шингэн	Цэвэрлэх байгууламжийн сараалжинд үүссэн хог хаягдлыг хуримтлуулан зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах	Цэвэрлэх байгууламж	-	-	-	-	Тухай бүр	Хог хаягдлын тухай хууль, 2017 он
Нийт				-	-	-	600.0	-	

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нийт авах дээжийн тоо, ш	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанарын мониторинг							
<p><i>Хорт хий, бохирдуулагч, дуу чимээний түвшин:</i></p> <ul style="list-style-type: none"> Тоос /TSP, PM10, PM2.5/ CO₂ SO₂ NO₂ Дуу шуугиан 	Уурын зуухны орчинд	Жилд 1 удаа (6-р сард) хэмжилт хийх	1 цэгт*1 удаа* 1 дээж	1	80.0	80.0	<ul style="list-style-type: none"> ✓ Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885 : 2008/ ✓ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
<p><i>Хорт хий, бохирдуулагч, дуу чимээний түвшин:</i></p> <ul style="list-style-type: none"> Тоос /TSP, PM10, PM2.5/ CO₂ SO₂ NO₂ 	Уурын зуухны яндангаас ялгарах утааны хэмжилт	Жилд 1 удаа (6-р сард) хэмжилт хийх	1 цэгт*1 удаа* 1 дээж	1	120.0	120.0	<ul style="list-style-type: none"> ✓ Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны агаар мандалд хаях утааны бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хэмжих арга MNS 5919:2008
Хөрсний чанарын мониторинг							
<p><i>Нянгийн бохирдол:</i></p> <ul style="list-style-type: none"> (1гр-д) Колититр Cl.perferringen s титр 	Цэвэрлэх байгууламжийн орчмоос	Жилд нэг удаа	2 цэгт * 1 удаа	2	40.0	80.0	<ul style="list-style-type: none"> ✓ Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл/MNS 3985 - 1987/ ✓ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008. ✓ Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991
<p>Хөрсөн дэх хүнд металлын агууламж тодорхойлох:</p> <ul style="list-style-type: none"> 6 хүнд металл (Cu, Zn, Cd, Pb, Cr, Ni) 	Уурын зуухны орчмоос	Жилд нэг удаа	2 цэгт * 1 удаа	2	50.0	100.0	

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нийт авах дээжийн тоо, ш	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
							✓ Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305 : 1995
Усны чанарын мониторинг							
<ul style="list-style-type: none"> Усны химийн ерөнхий шинжилгээ Усан дахь бохирдуулагч бодисуудын хэмжээ тодорхойлох (Хүнд металл-54) 	Ус хангамжийн эх үүсвэрийн худгуудаас	Жилд нэг удаа	3 цэгт*1 удаа	3	100.0	300.0	<ul style="list-style-type: none"> ✓ Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлагууд болон чанарын хяналт MNS 900:2018 ✓ Усны чанар. Газрын доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148 : 2010 ✓ Байгаль орчны хамгаалал, усан мандал. Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 3342 : 1982
Бохир усны хими/микробиологийн шинжилгээ	Цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал ус	Улиралд 1 удаа	1цэгт	4	150.0	600.0	✓
НИЙТ				-	-	1280.0	-

**БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь												Хариуцсан албан тушаалтан
			2023 оны												
			I сар	II сар	III сар	IV сар	V сар	VI сар	VII сар	VIII сар	IX сар	X сар	XI сар	XII сар	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2948.9	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Удирдлага, Ерөнхий инженер
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2600.0				+	+	+							Удирдлага, Ерөнхий инженер,
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Ерөнхий инженер
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600.0	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Байгаль орчны ажилтан
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1280.0				+	+	+	+	+	+	+	+		Байгаль орчны ажилтан

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Дундговь аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	3 хувь хэвлэж хүргүүлэх	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тодорхой тусгаж, фото зургаар баримтжуулсан байх	2023 оны 11 сарын 01-ний дотор	-	Ерөнхий инженер, Байгаль орчны ажилтан	-

**БҮЛЭГ 12. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
НЭГДСЭН ТӨСӨВ**

№	БОМТ-ний төрлүүд	Зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2948,9
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2600.0
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	600.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1280.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв		7928.9